

Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг
хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит болон харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчдын ажлын хэрэгцээний интернет сүлжээнээс олон нийтийн сүлжээ, онлайн тоглоом, видео сан бүхий сайтуудад нэвтрэхийг хориглосугай.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Мэдээллийн технологийн газар /О.Чинзориг/ болон дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД